



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/152/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг, Сайншанд сум

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас:99092469 Цахим хаяг:

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 90077079 Цахим хаяг:

Аудитор: Э.Батчимэг

Утас: 99032916 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.
Дорноговь аймгийн Төрийн аудитын газар, Сайншанд сум, Орон нутгийн өмчийн 3 дугаар байр


Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	13

1 Аудитын гэрчилгээ



Аудитын гол асуудал

2008 онд шүүхээр шийдвэрлүүлсэн гэх боловч хэн хариуцаж төлөх нь тодорхойгүй 1,913,228.0 төгрөгийн авлага тайлагнагдсан байна.

Энэ зөрчил нь санхүүгийн тайлангийн тогилуулга ба илчлэл үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаагаас гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийж, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэг нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цэцэрлэгийн эрхлэгч А.Мөнхчимэг-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 20-наас 2019 оны 2 дугаар сарын 21-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэг нь СӨБ-ын үйлчилгээний шинэ арга хэлбэрийг дэмжих замаар хүүхэд бүрийг зохион байгуулалттай сургалт, хөгжүүлэх үйл ажиллагаанд тогтмол хамруулж, бага насны хүүхдийг хөгжүүлэх ажлын чанарыг сайжруулна гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх насныханд анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэргэжилтэн Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэг санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous" програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэг дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд /Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн дагуу зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байгаа тул нийт зардлыг суурь үзүүлэлтээр сонгосонтой холбоотой юм.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны Нийт зардал 261,610.3 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 793.42 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь нэг удаагийн ажил гүйлгээний дүнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	39,243.80	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	3	39,243.80	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. 2018 оны жилийн эцсийн тайлан гаргахын өмнө буюу хуульд заасан хугацаанд бараа материалын тооллого хийгээгүй байна.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 249,763.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 249,746.9 мянган төгрөг буюу 100 хувьтай байна

2.11. Шилэн дансны мэдээлэл

Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар буюу өмнөх аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн Цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. 2008 онд шүүхээр шийдвэрлүүлсэн гэх 1913228 төгрөгийн авлагыг одоо болтол барагдуулаагүй, шүүхийн шийдвэр шийдвэр гүйцэтгэх байгууллагад очсон эсэх нь тодорхойгүй энэ асуудлыг шийдвэрлэх талаар анхаарч ажиллаагүй байна.
2. Бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-г нэр төрөл, үнийн дүнгээр тайлагнаагүй нийт дүнгээр тайлагнасан, бараа материалд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй
3. 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар НДШ-ийн өглөг 222,223.51 төгрөг байна

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

2008 онд шүүхээр шийдвэрлүүлсэн гэх 1913228 төгрөгийн авлагыг одоо болтол барагдуулаагүй , шүүхийн шийдвэр шийдвэр гүйцэтгэх байгууллагад очсон эсэх нь тодорхойгүй энэ асуудлыг шийдвэрлэх талаар анхаарч ажиллаагүй байна.

Энэ нь үнэн зөв байх , бодитой оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Хэрэв шүүхээр шийдвэрлүүлсэн асуудал байгаа бол Шүүхийн шийдвэрийг харьяалах шийдвэр гүйцэтгэх газарт албан ёсоор өгч хариуг авах , шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаар шаардлага тавьж ажиллах , авлагын барагдуулах талаар анхаарч ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид анхаарч ажиллана

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-г нэр төрөл , үнийн дүнгээр тайлагнаагүй нийт дүнгээр тайлагнасан , бараа материалд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй

Энэ нь Бодитой оршин байх , эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан заавар , НБББББичгийг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Бараа материалын тайланг нэр төрлөөр гаргадаггүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан заавар , Боловсрол , соёл , шинжлэх ухаан , спортын сайдын 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн А/40 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах , бараа материалд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тайланг нийт дүнгээр гаргасан

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар НДШ-ийн өглөг 222,223.51 төгрөг байна

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Авлага өглөгийг барагдуулж ажиллаагүй байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 заалтыг мөрдөж ажиллах , өр авлагыг тайлант хугацаанд барагдуулж ажиллах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид анхаарч ажиллана

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

СТ-1А

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	37,809,446.50	39,199,440.80
33	АВЛАГА	2,955,946.70	2,091,068.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,913,228.00	1,913,228.00
335	Бусад авлага	1,042,718.70	177,840.00
3351	Байгууллагаас авах авлага	412,878.70	
3352	Хувь хүмүүсээс авах авлага	629,840.00	177,840.00
35	БАРАА МАТЕРИАЛ	34,853,499.80	37,108,372.80
351	Түүхий эд материал	1,909,885.86	1,853,185.86
35110	Тусгай зориулалттай материал	1,874,885.86	1,742,885.86
35130	Эм боох материал	35,000.00	110,300.00
354	Хангамжийн материал	32,943,613.94	35,255,186.94
35410	Бичиг хэргийн материал	1,566,160.00	1,220,880.00
35420	Аж ахуйн материал	20,385,038.73	20,462,566.73
35440	Түлш, шатах тослох материал	5,551,000.00	4,832,150.00
35460	Хүнсний материал	900,365.00	2,377,540.00
35470	Бусад хангамжийн материал	4,541,050.21	6,362,050.21
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	613,386,275.78	528,326,419.17
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	613,386,275.78	528,326,419.17
392	Биет хөрөнгө	613,386,275.78	518,754,419.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	623,732,800.00	430,253,558.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	(59,424,027.04)	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,500,000.00	21,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(10,929,166.87)	(13,079,166.91)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27,949,690.00	37,362,490.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(11,774,264.90)	(16,551,834.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,362,985.33	52,024,985.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,747,627.03)	(28,644,939.06)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,691,283.00	38,178,683.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,767,454.39)	(4,081,414.29)
39217	Ном	1,792,057.68	1,792,057.68
393	Биет бус хөрөнгө		9,572,000.00
39301	Програм хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(250,000.00)	(250,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө		9,572,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III+II	651,195,722.28	567,525,859.97
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	693,379.00	222,258.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	693,379.00	222,258.00
413	Өглөг	693,379.00	222,258.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	693,379.00	222,258.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	650,502,343.28	567,303,601.97
51	Засгийн газрын хувь өрөлөө	650,502,343.28	567,303,601.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	52,908,436.08	62,480,436.08
51101	Өмч: - төрийн	52,908,436.08	62,480,436.08
512	Хуримтлагдсан үр дүн	595,948,451.20	503,811,483.54
51210	Өмнөх үеийн үр дүн	595,948,451.20	597,593,907.20
51220	Тайлант үеийн үр дүн		(93,782,423.66)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,643,456.00	1,011,682.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V	651,195,722.28	567,525,859.97

4417144353
EЮА0058 902570

СТ-2А

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Давсны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	147,980,800.00	302,926,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,496,000.00	47,163,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,496,000.00	47,163,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,496,000.00	47,163,200.00
1200045	Үнэ төлбөргүй хулээн авсан орлого	2,496,000.00	47,163,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		6,000,000.00
131007	Тусгай зорилдлын шилжүүлэгэс санхүүжих	145,484,800.00	249,763,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		6,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		6,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	134,306,330.34	261,610,332.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	134,306,330.34	261,610,332.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	119,201,330.34	247,718,005.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшлал	69,323,975.00	150,972,077.70
210101	Үндсэн цалин	69,323,975.00	150,972,077.70
2102	Ажлал олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,740,836.00	18,547,980.00
210201	Тэтгэврийн даатгал	4,960,896.00	12,387,275.00
210202	Тэтгэмжийн даатгал	555,988.00	1,488,825.00
210203	ҮОМШО-ний даатгал	694,985.00	1,283,490.00
210204	Ажилгүйдлийн даатгал	138,997.00	308,038.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,389,970.00	3,080,352.00
2103	Байр шингэлэлтэй холбоотой тогтмол зардал	9,928,644.00	14,284,455.00
210301	Гэрэл, цахилгаан	374,440.00	2,210,205.00
210302	Түлш, халаалт	9,524,204.00	11,434,250.00
210303	Цэвэр, бохир ус	30,000.00	640,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,530,253.00	9,674,162.00
210401	Бичиг хэрэг	397,640.00	1,308,480.00
210402	Тээвэр, шатахуун	1,054,220.00	2,899,570.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		720,000.00
210404	Ном, хэвлэл		21,660.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мөргөгчдийн устгал, ариутгал		270,000.00
210406	Бяга үнэгтэй, түргэн эхлэх, хэвийн эд зүйлс	3,478,393.00	4,454,452.00
2105	Нормативт зардал	16,961,050.00	31,450,682.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,950.00	62,900.00
210502	Холд, хуис	16,942,100.00	31,387,782.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	148,300.00	
210604	Урсгал засвар	148,300.00	
2107	Томилголт, зочны зардал		416,700.00
210702	Дотоод албан томилголт		416,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	301,000.00	242,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	301,000.00	242,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,867,272.34	22,129,448.23
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	22,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрогдол	9,867,272.34	22,107,448.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,105,000.00	13,892,327.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,105,000.00	13,876,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,045,000.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		13,876,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		16,127.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		16,127.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	13,674,469.66	41,315,867.07
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		135,098,290.73
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		4,944,332.81
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		130,153,957.92
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		(135,098,290.73)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	13,674,469.66	(93,782,423.66)

4417144353
EQA0056 902570

СТ-3А

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	145,484,800.00	255,763,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	145,484,800.00	255,763,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлэгээс санхүүжих	145,484,800.00	249,763,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		6,000,000.00
131104	Дээд шатны төсвийн засрагчийн төсөвт тусгагдан төсвөөс доод шатны төсвийн захирагчид кууварилсан хөрөнгө		6,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	110,207,951.00	240,913,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	110,207,951.00	240,913,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	95,102,951.00	227,020,672.50
2101	Цалин хэлс болон нэмэгдэл урвшил	66,918,991.00	150,532,200.00
210101	Үндсэн цалин	60,760,991.00	138,221,200.00
210102	Нэмэгдэл	2,058,000.00	4,111,000.00
210104	Урамшуулал	4,100,000.00	8,200,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,463,300.00	18,594,100.00
210201	Тэтгэврийн даатгал	4,749,300.00	12,775,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	542,900.00	1,163,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	678,500.00	1,454,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	135,600.00	290,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,357,000.00	2,909,000.00
2103	Байр шингэлттэй холбоотой тогтмол зардал	8,824,440.00	15,018,815.00
210301	Гэрээ, цахилгаан	622,440.00	2,809,205.00
210302	Тулц, халвалт	7,539,000.00	10,715,400.00
210303	Цэвэр, бохир ус	663,000.00	1,494,210.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,154,000.00	7,512,500.00
210401	Бичиг хэрэг	47,000.00	97,000.00
210402	Тээвэр, шатахуун	787,500.00	2,045,360.00
210403	Шуудан, холбоо, интернетийн талбар	24,500.00	760,200.00
210404	Ном, хэвлэл	80,000.00	189,960.00
210405	Хөг хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		270,000.00
210406	Бага үнэтэй, тургэн элэгдэх, ахуйн эв зүйлс	215,000.00	4,149,980.00
2105	Нормативт зардал	9,951,520.00	33,503,157.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	59,850.00	138,200.00
210502	Хоол, хүнс	9,891,670.00	32,864,957.50
210503	Нормын хувиар, зөвлөн эдлэл		500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	62,000.00	200,000.00
210604	Урсгал засвар	62,000.00	200,000.00
2107	Томилголт, зочны зардал		416,700.00
210702	Дотоод албан томилголт		416,700.00
2108	Бусаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний талбар, хураамж	301,000.00	242,500.00
210801	Бусаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний талбар хураамж	301,000.00	242,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	427,700.00	1,000,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн найдлаг хийх	427,700.00	1,000,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,105,000.00	13,892,327.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,105,000.00	13,876,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,045,000.00	
213208	Хөдөө орон нутыг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг		13,876,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,000.00	
2133	Удсан төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		16,127.50
213303	Төвөөрүүлэх шилжүүлэг		16,127.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	35,276,849.00	14,850,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	219,000.00	14,850,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	219,000.00	14,850,000.00
2200	Дотоод эв гүснэрээр	219,000.00	14,850,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	219,000.00	14,850,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(219,000.00)	(14,850,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	35,057,849.00	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	35,057,849.00	

4417144353
ENC0006 302570

СТ-4А

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооноос нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				*	
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл					
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
C07	Тайланг үеийн үр дүн					
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл					
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,908,436.08	1,645,456.00	595,948,451.20		650,502,343.28
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			1,645,456.00		1,645,456.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,908,436.08	1,645,456.00	597,593,907.20		652,147,799.28
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(633,773.65)			(633,773.65)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					
D08	Тайланг үеийн үр дүн	9,572,000.00		(93,782,423.66)		(84,210,423.66)
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	62,480,436.08	1,011,682.35	503,811,483.54		567,303,601.97

4417144353
EHOA0056 9025707

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хуви
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	249,763,000.00	249,746,872.50	16,127.50	100.0%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	249,763,000.00	249,746,872.50	16,127.50	100.0%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧЛИГЭЭНИЙ ЗАРДАЛ	235,886,800.00	235,870,672.50	16,127.50	100.0%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	150,532,200.00	150,532,200.00		100.0%
210101	Үндсэн цалин	138,221,200.00	138,221,200.00		100.0%
210102	Нэмэгдэл	4,111,000.00	4,111,000.00		100.0%
210104	Урмшуулал	8,200,000.00	8,200,000.00		100.0%
2102	Ажил олгогчдоос нийгэмийн даатгалд төлөх шимтгэл	18,594,100.00	18,594,100.00		100.0%
210201	Тэтгэрийн даатгал	12,775,900.00	12,775,900.00		100.0%
210202	Тэтгэмжийн даатгал	1,163,700.00	1,163,700.00		100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,454,600.00	1,454,600.00		100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	290,900.00	290,900.00		100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	2,909,000.00	2,909,000.00		100.0%
2103	Байр ашигламттай холбоотой тогтмол зардал	15,018,900.00	15,018,815.00	85.00	100.0%
210301	Гэрэл, цахилгаан	2,809,300.00	2,809,205.00	95.00	100.0%
210302	Туви, халаалт	10,715,300.00	10,715,400.00	(100.00)	100.0%
210303	Цэвэр, бохир ус	1,494,300.00	1,494,210.00	90.00	100.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	6,870,200.00	6,862,500.00	7,700.00	100.1%
210401	Бичиг хэрэг	100,000.00	97,000.00	3,000.00	103.1%
210402	Тээвэр, шатахуун	2,050,000.00	2,045,360.00	4,640.00	100.2%
210403	Шуудан, холбоо, интернетын төлбөр	760,200.00	760,200.00		100.0%
210404	Ном, хэвлэл	190,000.00	189,960.00	40.00	100.0%
210405	Хөг хаягдал зайлуулж, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	270,000.00	270,000.00		100.0%
210406	Бага үнэтэй, тургэн эзлэх, асуйн эд зүйлс	3,500,000.00	3,499,980.00	20.00	100.0%
2105	Норматив зардал	33,504,500.00	33,503,157.50	1,342.50	100.0%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	138,200.00	138,200.00		100.0%
210502	Хөөл, хунс	32,866,300.00	32,864,957.50	1,342.50	100.0%
210503	Нормын хувиас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00		100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,705,000.00	9,700,000.00	5,000.00	100.1%
210604	Урсгал засвар	9,705,000.00	9,700,000.00	5,000.00	100.1%
2107	Томлолт, зочны зардал	418,400.00	416,700.00	1,700.00	100.4%
210702	Дотоод албан томлолт	418,400.00	416,700.00	1,700.00	100.4%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, кураамж	242,500.00	242,500.00		100.0%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хур	242,500.00	242,500.00		100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,001,000.00	1,000,700.00	300.00	100.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,001,000.00	1,000,700.00	300.00	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,876,200.00	13,876,200.00		100.0%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг				
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг				
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг				
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,876,200.00	13,876,200.00		100.0%
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,876,200.00	13,876,200.00		100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	249,763,000.00	249,763,000.00		100.0%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	249,763,000.00	249,763,000.00		100.0%
131007	Тусгай зориулалтын шилжүүлэгээс санхүүжих	249,763,000.00	249,763,000.00		100.0%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	17.00	17.00		100.0%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00		100.0%
620003	Үйлдэх ажилтан	8.00	8.00		100.0%
620004	Гэрээт ажилтан				
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)				
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД				
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА				
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ				
64	ЭМЧЛҮҮЛЭГ СЭДИЙН ТОО				
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				

4417144353
 6ЮА0058 9025707

НТ-2

АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,000,000.00	6,000,000.00		100.0%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,000,000.00	6,000,000.00		100.0%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,000,000.00	6,000,000.00		100.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	6,000,000.00	6,000,000.00		100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,000,000.00	6,000,000.00		100.0%
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,000,000.00	6,000,000.00		100.0%
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,000,000.00	6,000,000.00		100.0%
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	6,000,000.00		100.0%
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого				
131106	Төсвийн урамшуулал				
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

4417144353
 EHOA0056 9025707